# НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/16 Улаанбаатар хот

"Улаанбаатар Марафонд нэгдэцгээе"
Нийслэлийн Засаг даргын нэрэмжит
цом аялуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33,5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 147 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Улаанбаатар Марафонд нэгдэцгээе" цом аялуулах аяныг 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийг дуустал 60 хоногийн хугацаанд нийслэл хотын хэмжээнд зохион байгуулсугай.

2. "Улаанбаатар Марафонд нэгдэцгээе" цом аялуулах аяныг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Цомыг аялуулахад шаардагдах 732.000/Долоон зуун гучин хоёр мянган/ төгрөгийг "Улаанбаатар Марафон-2017"-ыг зохион байгуулах төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Цом аялуулах арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж дүгнэхийг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

1116128787 9077448

D:\2017\2017 tushaal\A tushaal "2017"\marathon tsom aylah.docx

115050004

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны ...03 дугаар...... сарын 20...-ны өдрийн
...А/16... дугаар тушаалын хавсралт

“Улаанбаатар Марафонд нэгдэцгээе”
Нийслэлийн Засаг даргын нэрэмжит
цом аялуулах

| № | Зардлын нэр | Нийт дүн /төг/ |
|---|---|---|
| 1. | Цом 12х50.000/төг | 600.000 |
| 2. | Хавтас 12х11000төг | 132.000 |
| **ДҮН:** | | **732.000** |

Боловсруулсан:
Нийтийн биеийн тамирын
хөгжлийн хэлтсийн А.Болдмаа

Хянасан:
Нягтлан бодогч О.Эрдэнэцэцэг